



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/8/СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020

Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө	6
2.8.2 Авлага.....	7
2.8.3 Бараа материал	7
2.8.4 Үндсэн хөрөнгө	8
2.8.5 Өр төлбөр	8
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	12
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	25
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА Л.ЦЭЦЭГДАРЬ ТАНАА
2020.03.25 № 1-6/350 танай _____-ны № _____-т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Хязгаарлалттай санал дүгнэлт	
<p>Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Аудитын гол асуудал

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 6 төсвийн шууд захирагч, 3 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлангаас 5 байгууллагыг түүвэр аудитад хамруулж, аудитаар 3 зөрчилгүй, 1 хязгаарлалттай санал дүгнэлтийг өглөө.

Ерөнхий боловсролын сургууль нь 18.5 сая төгрөгийн хоол хүнсний материал бэлтгэхдээ худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, дотуур байрны хүүхдийн хоол нормативаас 2.5 сая төгрөгөөр хэтэрсэн, 5.0 сая төгрөгийн бусад зөрчил нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт авсан.

Мөн Хүүхдийн цэцэрлэг 0.3 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 3.7 сая төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2.2 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 2.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил илэрсэн.
/Зөрчлийн дэлгэрэнгүйг Аудитын тайлангийн №4 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалтад харуулав/

Тус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд материаллаг байдлын түвшинг 16.9 сая төгрөгөөр тогтоосон. Төсвийн шууд захирагчдын тайланд илэрсэн нийт зөрчил нь 34.4 сая төгрөг буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 2 дахин давсан байна.

Үүрэг, хариуцлага

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Алтанширээ сумын Засаг дарга Л.Цэцэгдарь танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-аас 2020 оны 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/65 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 759.3 сая төгрөгийн 1 хувь буюу 7.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 16.9 сая төгрөгөөр тогтоосон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 1 /Ерөнхий боловсролын сургууль/ дүгнэлт өгсөн байна. 5 байгууллага түүвэр аудитад хамрагдсан.

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 93.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 58.9 сая төгрөгийн 14 алдааг аудитын явцад залруулж, 0.4 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23.3 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 10.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг хүргүүлсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 58.9 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Ерөнхий боловсролын сургууль ажиллагсдад олгосон 27 тонн нүүрсний үнэ 2.7 сая төгрөгийг түлш халаалтын зардалд бичсэнийг нэг удаагийн тэтгэмжийн зардалд залруулсан, БСШУЯ-аас ирүүлсэн 0.7 сая төгрөгийн түрээсийн сурах бичгийг орлогод аваагүй орхигдуулсан байсныг орлогод авсан, дутагдуулсан 1.7 сая төгрөгийн хүнсний материалыг бүртгэлээс хасахдаа авлага үүсгэлгүйгээр хоолны зардалд бичсэнийг залруулж авлага үүсгэсэн, орон нутгийн төсвөөс санхүүжсэн 33.1 сая төгрөгийн санхүүжилтийг буруу дансаар бүртгэснийг, жилийн эцэст төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөөр төсвийн гүйцэтгэлийн тохируулга хийлгүй төсвийн гүйцэтгэл зөрүүлсэн байсныг засаж төрийн сангийн хуулгатай тааруулсан.
- Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд 11.7 сая төгрөгийн байгууллагаас авах авлагыг хасаж залруулга хийсэн.
- Сум хөгжүүлэх сангийн тайланд 4.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг дутуу тооцсоныг залруулсан.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 59.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 48.4 сая төгрөг болж 11.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	59.8	48.4	11.4	80
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	59.8	48.4	11.4	80

Эх сурвалж: Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 48.4 сая төгрөг нь Засаг даргын Тамгын газрын Ахмадын сан 4.2 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургуулийн Ахмадын сан 1.4 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн Ахмадын сан 0.7 сая төгрөг, Соёлын төвийн Ахмадын сан 0.2 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 4.6 сая төгрөг, Сум хөгжүүлэх сан 28.7 сая төгрөг, Нөхөн сэргээлтийн сан 6.3 сая төгрөг, Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилт 1.9 сая төгрөг, Соёлын төвийн нэмэлт санхүүжилт 0.1 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилт 0.3 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 139.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 153.4 сая төгрөг болж, 14.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.1	0.3	0.2
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	0	4.8	4.8
Бусад авлага	12.2	0.8	-11.4
Зээлийн авлага	126.9	147.5	20.6
Дүн	139.2	153.4	14.2

Эх сурвалж: Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдэл 152.3 сая төгрөгийн авлага, Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн даатгалын шимтгэл, суутгаагүй цалингийн урьдчилгаа, Хүүхдийн цэцэрлэгийн хувь хүний орлогын албан татвар зэрэг 1.1 сая төгрөгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт: Ерөнхий боловсролын сургууль - Балансын дансанд тусгасан авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ... баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “үнэн зөв байх”, “эрх ба үүрэг” батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 166.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 207.8 сая төгрөг болж, 41.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	44.2	60.4	16.2
Эм боох материал	0.0	4.4	4.4
Бэлэн бүтээгдэхүүн	0.1	0.8	0.7
Бичиг хэргийн материал	1.1	2.3	1.2
Аж ахуйн материал	78.6	86.7	8.1
Түлш шатах тослох материал	17.9	24.2	6.3
Хүнсний материал	12.2	9.9	-2.3
Бусад хангамжийн материал	12.4	11.6	-0.8
Мал амьтад	0.0	7.5	7.5
Дүн	166.5	207.8	41.3

Эх сурвалж: Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэлд Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 5.1 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 40.1 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 84.9 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 32.1 сая төгрөг, Соёлын төв 15.4 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 30.2 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт: Ерөнхий боловсролын сургууль - Хоол хүнсний 18.5 сая төгрөгийн зардалд Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,260.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,468.8 сая төгрөг болж, 208.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,361.3	2,603.9	242.6
Хуримтлагдсан элэгдэл	-83.3	-173.3	-90.0
Авто тээврийн хэрэгсэл	215.7	321.5	105.8
Хуримтлагдсан элэгдэл	-88.2	-109.5	-21.3
Машин тоног төхөөрөмж	359.8	388.0	28.2
Хуримтлагдсан элэгдэл	-210.2	-225.5	-15.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	161.6	182.4	20.8
Хуримтлагдсан элэгдэл	-124.8	-129.4	-4.6
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1.8	5.5	3.7
Бусад үндсэн хөрөнгө	864.2	862.6	-1.6
Хуримтлагдсан элэгдэл	-317.2	-383.4	-66.2
Ном	12.1	23.5	11.4
Програм хангамж	2.0	2.0	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-1.9	-1.9	0.0
Бусад биет бус хөрөнгө	107.9	102.4	-5.5
Дүн	3,260.8	3,468.8	208.0

Эх сурвалж: Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2.1 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 3.0 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 9.1 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 16.9 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 2.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл 242.6 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Засаг даргын Тамгын газар 105.7 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, сумын Засаг даргын Тамгын газраас Соёлын төвд 9.6 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, Ерөнхий боловсролын сургуулиас Хүүхдийн цэцэрлэгт 11.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж балансаас балансад шилжүүлсэн байна. Боловсрол соёл, шинжлэх ухааны яамнаас Ерөнхий боловсролын сургуульд 5.5 сая төгрөг, Соёлын төвд 3.7 сая төгрөгийн номыг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна. Нийт 30.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталснаас Эрүүл мэндийн төв 7.3 сая төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 0.8 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 6.7 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 3.9 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 0.8 сая төгрөг, Соёлын төв 5.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3.1 сая төгрөг болж, 1.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	2.0	0.4	-1.6	20
Байгууллагад төлөх өглөг	0.1	2.6	2.5	260
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	0.1	0.1	10
Дүн	2.1	3.1	1.0	147

Эх сурвалж: Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд 0.4 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг, 2.6 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 0.1 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг байна.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,624.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,875.5 сая төгрөг болж, 251.0 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,252.9	2,252.9	0	0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	10.7	10.7	0	0
Хуримтлагдсан үр дүн	-622.8	-370.5	-252.3	59.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,983.7	1,982.4	1.3	99.9
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	3,624.5	3,875.5	-251.0	106.9

Эх сурвалж: Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансанд өөрчлөлт ороогүй.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга байхгүй.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Алтанширээ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны Сумын 2019 оны төсөв батлах тухай 22 дугаар тогтоолд зааснаар Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 22.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 34.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 157 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	1.5	3.1	-1.6	206
Хадгаламжийн хүүгийн орлого	5.8	7.7	-1.9	133
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	9.8	18.3	-8.5	187
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	0.1	0.0	0.1	0
Бууны албан татвар	1.4	0.9	0.5	69
Улсын тэмдэгтийн хураамж	0.8	0.9	-0.1	114
Хогны төлбөр	2.6	2.7	-0.1	105
Түгээмэл тархацтай ашигт малтмал	0.1	0.7	-0.6	720
Хүү торгуулийн орлого	0.2	0.4	-0.2	207
Нийт дүн	22.3	34.7	-12.4	157

Үйл ажиллагааны орлого 1.6 сая төгрөгөөр давсан нь 2018 оны тайлангийн зөрүү нэмэгдэж орсноос, Хадгаламжийн хүүгийн орлого 1.9 сая төгрөгөөр давсан нь иргэдийн хадгаламжийн үйлчилгээ нэмэгдсэнээс, Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 8.5 сая төгрөгөөр давсан нь 2017, 2018 оны ноос, арьс ширний урамшууллын татвар орсноос, Улсын тэмдэгтийн хураамж 0.1 сая төгрөгөөр давсан нь 2019 оны эхнээс эхлэн нотариатын үйлчилгээ үзүүлж эхэлснээс, Хог хаягдлын хураамж 0.1 сая төгрөгөөр давсан нь суманд барилгын ажил болон засварын ажил хийсэн аж ахуйн нэгж байгууллагаас хураамж төлүүлснээс, Түгээмэл тархацтай ашигт малтмал 0.6 сая төгрөгөөр давсан нь суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр барилгын болон засварын ажил хийсэн аж ахуйн нэгж байгууллагаас элс хайрга ашигласны төлбөр төлүүлснээс, Хүү торгуулийн орлого 0.2 сая төгрөгөөр давсан нь суманд торгуулийн машин ажиллуулж эхэлснээс, Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 0.1 сая төгрөгөөр тасарсан нь энэ үйл ажиллагаа явагдаагүйтэй, Бууны албан татвар 0.5 сая төгрөгөөр тасарсан нь нас барсан 1, буугаа хасуулсан 2, зарсан 2, хулгайд алдсан 1, цагдаад хураалгасан 1, эрэн сурвалжлуулж, байгаа 1, татвараа төлөөгүй 2 иргэнтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,544.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,354.0 сая төгрөгийг урсгал зардалд, 190.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 470.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 13.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 791.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 186.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 82.5 сая төгрөгийг үндсэн боон туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,544.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 468.8 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 9.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 791.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 178.3 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 51.2 сая төгрөг, нийт 1,498.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 0.8 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвийг биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,515.8 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт дутуу хийгдсэн, мөн төсөвт байгууллагуудын зарцуулалт хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Эрүүл мэндийн төв, сумын Засаг даргын Тамгын газар дээд шатны төсвийн захирагчаас 0.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 19.8 сая төгрөг, нийт 20.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бусад урсгал шилжүүлэгт 0.7 сая төгрөг, бараа ажил үйлчилгээний зардалд 17.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт: Засаг даргын Тамгын газар – Үндсэн цалингийн зардлаас 2.1 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.

Ерөнхий боловсролын сургууль - Дотуур байрны хүүхдийн хоол 2.5 сая төгрөгөөр нормативаас хэтэрсэн байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

Төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалт, бусад гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 345.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” санал дүгнэлт

Залруулагдаагүй 34.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 16.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшингээс 2 дахин давсан тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт өглөө.

Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	365,640.7	409,682.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	59,831.7	48,441.3
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	59,831.7	48,441.3
31210	Төгрөг	59,831.7	48,441.3
31211	Төрийн сангийн харилцах	59,831.7	48,441.3
33	АВЛАГА	139,213.1	153,439.8
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	100.5	374.6
33400	Зээлийн хүүгийн авлага	-	4,840.0
33500	Бусад авлага	12,238.5	774.4
33510	Байгууллагаас авах авлага	12,049.5	585.4
33520	Хувь хүмүүсээс авах авлага	189.0	189.0
33600	Зээлийн авлага	126,874.1	147,450.8
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	126,874.1	147,450.8
33612	Хувь хүмүүст олгосон зээл	126,874.1	147,450.8
35	БАРАА МАТЕРИАЛ	166,595.9	207,801.1
35100	Түүхий эд материал	44,287.2	64,797.2
35110	Тусгай зориулалттай материал	44,287.2	60,399.1
35130	Эм боох материал	-	4,398.1
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4.2	804.0
35400	Хангамжийн материал	122,304.6	134,659.9
35410	Бичиг хэргийн материал	1,131.8	2,273.2
35420	Аж ахуйн материал	78,529.6	86,666.2
35440	Түлш, шатах тослох материал	17,944.0	24,253.0
35460	Хүнсний материал	12,275.3	9,894.9
35470	Бусад хангамжийн материал	12,423.9	11,572.5
35600	Мал амьтад	-	7,540.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,260,867.1	3,468,884.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,260,867.1	3,468,884.1
39200	Биет хөрөнгө	3,152,790.6	3,366,294.1
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,361,289.5	2,603,898.5
39202	Хуримтлагдсан элэгдэл	(83,293.7)	(173,303.3)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,738.8	321,498.8
39204	Хуримтлагдсан элэгдэл	(88,163.9)	(109,561.7)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	359,801.2	387,986.4
